

“АЧЛАЛТ НОМ” ХЭМЭЭХ

ЁС СУРТАХУУНЫ СУРГААЛЫН ТУХАЙ

Доктор /Ph.D/ М.Золзаяа

Түлхүүр үг: ачлал-тахимдуу, жэнь, и, ли, синь, ёсыг засах тэнхим

Товч утга: Монголчууд “Оюун түлхүүр” хэмээх ёс суртахууны сурах бичигтэйн адил Хятадын Хан улсын үеэс бичиг үсэгт эхлэн суралцагч “Шүлэглэлт ном”, “Шүүмжлэл өгүүлэл”, “Ачлалт ном” гурвыг юун түрүүнд уншиж мэдээд, дараа нь Күнзийн суртлын бусад сонгодог бүтээлүүдийг үздэг бол Энэтхэг, Төвдөд “Панчантра буюу таван ном”, Нагаржунайгийн “Ардыг тэжээх аршааны дусал” зэрэг зохиолыг шамдан судалдаг байжээ. Энэ нь бичиг үсэгт сурч буй хүүхэд залуусыг уншиж бичихэд сайжруулахаас гадна ёс суртахууны хүмүүжил олгох зорилготой ажээ. Энэтхэг, Хятадын дээрхи сургаалын зохиолуудыг монголын мэргэд эх хэлнээ хөрвүүлсэн билээ. Энэхүү өгүүлэлд Лувсанбалдангийн нийтлүүлсэн “Ачлалт номын тухай”-г эшлэн үзсэн болно.

Хятадад НТӨ 200-аад оны үед зохиогдсон “Ачлалт ном” буюу “Тахимдуу ном”-ыг /Да сё цзин яань-и/ 1307 онд Бултөмөр орчуулж монгол хэлээр, улсын дөрвөлжин бичгээр хэвлэсэн гэдэг баримт бий. Тэртээ 480 онд Монгол, Сяньби аймгийн мэргэн гүүш нар эртний Хятадын “Ачлалт ном”-ыг монгол хэлнээ орчуулж байсан хийгээд XIX-XX зууны үед Өвөр Монголд дөрвөн удаа орчуулагдсан тухай эрдэмтэн Х.Лувсанбалдан тэмдэглэжээ.¹ Энэ тухай нэрт түүхч Г.Сүхбаатар “Вейгийнхэн /Тоба нар/ Лоян хотод нүүж очоод хятад хэлээр нэвтэрхий тул Сяо Веньди хааны зарлигаар “Ачлалт ном”-ыг харь /тоба/ хэлээр орчуулан улсын иргэдэд зааж төрийн хэлний “Ачлалт ном” хэмээн нэрлэх болжээ”² хэмээн Вей улсын судраас эш татан бичсэн байна. Г.Сүхбаатар, Мажарын эрдэмтэн Л.Лигети нар тэр үед “Тоба-хятад хэлний толь”³ байсан гэж үзсэн билээ. А.М.Позднеев “уг зохиолын барыг сийлэх, улмаар хэвлэх, тараах ажилд хааны ордны бүх албан тушаалын хүмүүсийг дайчлан төв бичгийн яам гүйцэтгэсэн” гэж /Лекции по истории монгольской литературы. СПб., 1886/ дурьдсан байна. 1961 онд эрдэмтэн Х.Лувсанбалдан эх хэлнээ орчуулж, эрдэм шинжилгээний галигт буулгаж хэвлүүлсэн бол, 2004 онд Ч.Нарантуяа⁴ монгол бичгээс кириллээр хөрвүүлжээ. Уг зохиолыг Юань улсын үеийн төрийн ордны сургалтанд өргөн ашиглаж байснаас үзвэл монголчуудын ёс суртахууны үнэлэмжид нөлөөлсөн нь лавтай. Юань улсын үеийн сургуульд нийт сурагчдыг зургаан анги болгон доод, дунд, дээд гэж хуваагаад доод анги тоглоом, урлаг, соёл, хүмүүнлэг ёс судална. Дунд ангид ёс суртахууны хичээл үзэж “Их суртахуйн тайлбар бүлэг”, “Шүүмжлэл өгүүлэл”, “Ер дунд бичиг”, “Мэн-зын тухай тайлбар” зэргийг судлах ёстой байв. Ингээд шалгалт өгч дээд ангид дэвшин сууна.⁵ Үүнийг нотлох нэгэн тайлбар бол “Улсын хөвгүүнийг хүмүүжүүлэхийн баруун этгээдэд давхар саравчын тэргүүн тэнхимийг ёсыг засах тэнхим гэнэ” гэж монгол хэлний “Хорин наймтын тайлбар толь”-д⁶ байна. Энэ нь тэр үеийн улсын хөвгүүдийн сургуульд “ёсыг засах” нэртэй ёс суртахууны тэнхим байжээ гэж үзэхэд хүргэнэ.

Эл сургаалын зохиол нь Монголчуудын дунд “Ачлалт ном, Тахимдуу ном” гэсэн хоёр янзын нэрээр дэлгэрчээ. Монгол хэлний тайлбар тольд “Тахимдуу” нь ачлал, элбэрэл⁷ гэсэн утгатай үг гэж тайлбарлажээ. Ерөөс “ачлал” нь эцэг эхээ өргөн үйлчлэх, эзэн дээдэст шударга үйлчлэх, өөртөө шударга нэртэй

явахыг хэлнэ гэж "Ачлалт ном"-д өгүүлдэг. Зарим судлаачид уг зохиолыг бүтнээр нь Күнз бичсэн мэтээр явцуурах нь ташаарсан хэрэг болно. Энэхүү "Ачлалт ном" нь Күнзийн сургаалууд, Хятадын уран зохиолын сонгодог өв "Шүлэглэлт ном" хоёроос эшлэн авч найруулсан сургаал юм. Их мэргэн Күнз НТӨ 551-478 онд амьдарч байсан гэж үзвэл түүнийг таалал төгссөнөөс хойно 270-аад жилийн дараа түүний шавь нар "Ачлалт ном"-ыг эмхэтгэсэн байна. "Ачлалт ном"-д: -Мауши бичигт өгүүлснээр гэж бичсэн нь эртний "Шүлэглэлт ном"-оос эшлэн оруулсныг хэлж байна.

Зохиолд их төлөв Күнзийн сургаалуудаас орсон бөгөөд ноёд түшмэдээс эхлээд жирийн иргэнийг хүртэл нийт хүмүүст тохирох ёсыг өгүүлэн, эцэг эхийг хүндэтгэх, элбэрэл тахимдууг хичээх тухай заан сургажээ. Ёс суртахууны хэм хэмжээг өгүүлсэн арван найман бүлэгтэй. Эдгээрээс 2, 3, 4, 7-9, 11-р бүлэг нь төр ёстой холбоотой: 5, 6, 10, 12-17 нь бие хүний ёс суртахуунтай, 1, 18-р бүлэг нь эцэг эхээ ачлахтай тус тус холбогдсон гарчигтай байна. Хувь хүний ёс суртахууны төлөвшлийг эцэг, эхээ хэр ачилж байгаагаар тодорхойлогдоно гэдэг нь зохиолын гол агуулга юм. "Ачлалт ном" нь тахимдуу ёст хүнийг суурь болгоод, түүнд түшиглэж гэр бүл, нийгэм, төр, дэлхий ертөнцийг түвшин болгоход чиглэгдсэн сургаал гэж үзэж болно.

Мэргэдийн **эрдэм** хийгээд **сайн нөхрийн тусыг** төрийн үйл хэрэгт чухалчлан үздэг дорно дахины нийтлэг ёсыг "Ачлалт ном"-д өгүүлэхдээ: *...эртний хаадын дэргэд долоон түшмэл зөвлөн ятгаж байсан тул хаан ёс бус хэрэг үйлдэвч улсаа алдаагүй /Ятгах сануулах XV бүлэг/, харин доод тушаалын хүнд зөвлөн сануулагч сайн нөхөр байсан тул тэд сайн нэрээ алдаагүй* хэмээнэ. Эндээс үзэхэд монголчуудын төрийг эрдмээр засах сургаалтай адил утга санаа "Ачлалт ном"-д байна. Эрдмээр засна гэдэг нь төрийг **өршөөлөөр засахтай адил**. Нөгөө талаар "эрдэмт хүн" өршөөлгүй аваас нэр төрөө алдана. Мөн *"дээрээс эв найртай явсны тул хаан хүн ихэс дээдэс, өчүүхэн боолд хүртэл найртай эвтэй болмуй"* /Тахимдуу болохын ач үр хүртэх XVI бүлэг/ хэмээнэ. Эв эеийг эрхэмлэх ёс эртнээс эхтэй бөгөөд үүнийг баримтлан дагаваас шударга төр хийгээд тэгш эрхтэй ард түмэн орших талаар ийн өгүүлсэн байна.

Ачлалт номын "Угийг нээж төр, ёс хоёрыг тодорхой болгосныг өгүүлэх тэргүүн бүлэг"-т Күнз бээр: **тахимдуу** хэмээх нь ааль авирын төв язгуур бөгөөд соёл сургаал үүнээс эхэлнэ. *Эцэг эхээс төрсөн биеэ хайрлан эс эвдүүлвэл тахимдуу болохын үүсгэл. Төр, ёсоор явж сайн нэр алдаршуулаад эцэг, эхийн сайныг мандуулваас тахимдуу болохыг үзүүлнэ. Эцэст нь хан хүнд чин үнэнчээр /синь М.З/ хүчийг өгөх явдал болно* гэж сургасан байна. Зохиолд сургаснаар гагц эцэг, эхээ өргөвөл тахимдуу болж буй биш юм. **Төв язгуураар явна** гэдэг бол хүн өөртөө болон бусдад, нийгмийн төлөө сургаал ёсоор явна гэсэн үг. Үүнийг лавшруулан үзвэл Күнз "Шүүмжлэл өгүүлэл" зохиолдоо "Хүн болвоос эцэг эхээ ачилж, ихэс дээдсийг хүндлэвээс дээдэст тэрслэгч цөөн бөлгөө. Дээдэст тэрслэгч үгүй аваас самуун үйлдэхүйд дурлагч үгүй. ...Эцэг, эхээ ачилж, ихэс дээдсээ хүндлэх нь өршөөлийн суурь буюу" /I.II/⁸ хэмээжээ. Үүнээс үзвэл өршөөл хийгээд соёл сургаалын үндэс нь ачлал байна. "Өршөөл" нь өөр бусдыг хайрлах чанар, нөгөө талаар буруу, муу үйлийг ялган таниж засаж залруулах эрмэлзлэл гэж болно. Хүмүүн бие, хэл, сэтгэлээ муу үйлээс ангижруулж, бусдад энэрэн нигүүлсэхүй сэтгэлээр тус үзүүлэх нь **өршөөнгүй сэтгэлийн** чадвар юм.⁹ Түүнчлэн эхээ хайрлах, эзнээ хүндлэх ёсыг нийлүүлэн эцгээ хүндлэж ачлах ёстой / V бүлэг/ ажгуу. Мөн "Туйлын эрдмийг бадруулах" нэртэй XIII бүлэгт: *"...тахимдууд сургана гэдэг дэлхий дахины эцэг хүнийг*

хичээнгүйлж байгаа хэрэг” гэж өгүүлдэг. Энэхүү “эцэг” гэдэг ойлголт нь ачлалыг үүсгэж чадах хүн бүр өөрөө эцэг буюу эрдэмт иргэн болох учралтайг тодорхойлж байна.

Эцэг, эхийн ачийг хариулах ёсыг хүүхдэд багаас нь сургах талаар “эцэг, эхээ хайрлая гэвэл өвдөг чинээ нялхаасаа эхлэх /IX бүлэг/ хэрэгтэй” гэнэ. Энэхүү “хайрлахуй сэтгэл” хэмээхийг Күнзийн залгамжлагч Моист ёс зүйд “жэнь-хүн ёс”, “и-шударга ёс”-ыг /Күнз/ дагана гэдэг нь “бүхнийг хамарсан хайрыг дагагч” гэж тодорхойлсон болно. Мөн Хятадын “Бумбын сургаалд” “хайр гэдэг нь өрцний гүн дэх бор зүрхийг догдлуулдаг хүчтэй. Ухаантай хүн л хайрлаж тэтгэдэг. Ховор цөөнийг хайрлаж олшруул, хар хорыг ч хайр итгэлээр хариул¹⁰” гэж тэвчээртэйгээр мууг засаж залруулах нь **хайрын ёс** гэж үзжээ. Эцэг, эхээ хайрлан тэжээж чадваас олон иргэний тахимдуу ёсон болно /VI бүлэг/. Тэгэхээр “хайр” нь хүнлэг ёс /жэнь/, шударга, ухаалаг чанар, тэвчээр, итгэл зэргийг агуулсан байна. Энэ сургаалын зохиолд “**ачлал**” хэмээх ойлголтыг өргөн хэрэглэдэг. Жишээ нь: эцэг эхийн ачлал, сайдуудын ачлал гэх зэрэг. Энд “Хөвгүүн эцгийн үгийг дагавал ачлал болно /XV бүлэг/” хэмээжээ. Өөрөөр хэлбэл хайрлал, хүндлэл хоёр тэгшид байж **ачлалыг** үүсгэнэ гэдэг. Хайргүй хүндлэл, хүндлэлгүй хайр гэж байхгүй юм. Тймээс эцэг, эхийг ачлахад хайр нэгэн адил байх ёстой. Ачлалыг буруушаагчид эцэг, эхгүй /XI бүлэг/ төдийгүй ёслолгүй /ли/ байна. Хятадын ёс зүйд “ли” буюу ёслол нь хүний оршихуйн үндэс учраас ахуй, ёс суртахууны ухамсрын нэгдэл гэж үздэг.

Ачлал үүсгэх хамгийн тулгуур нь хүндлэл гэдгийг тодорхой өгүүлдэг. Тухайлбал, “Тэнгэрийн хөвгүүнийг өгүүлэх” II бүлэгт: “өөрийн эцэг эхийг хүндлэж байвал бусдыг хөнгөнөөр үздэггүй. Нэгэн хүнд баяр баясгалан байвал бусад нь тийм гэж итгэн дагана” гэжээ. Нэг хүний хүндлэх, ачлах ёс нь олон хүнд үлгэр дууриалтай хийгээд үр дагавар нь ямар байхыг харьцуулан “Ганц хүнийг хүндлэвээс мянга түмэн хүн баясжуу” /XII бүлэг/ гэдэг. Олон иргэнийг өгүүлэх зургадугаар бүлэгт “Тэнгэр, газар, хүний ёсыг мэдэж болгоомжлон явж эцэг эхээ тэтгэх нь олон иргэний ёс болой” гэнэ. Энэхүү “тэнгэрийн ёс, газрын ёс, хүний ёсыг мэдэх” гэгч нь юу вэ? Эцэг, дээд засаглал-тэнгэр, эх-газар гэдэг нь Хятадын байгалийн философийн арга, билигийн /инь, янь харилцан үйлчлэл/ ёсноос эхтэй үзэл юм. Күнз болон түүнийг баримтлагч Сюнь-з нар “хүн, тэнгэр, газар нь нэгдмэл болон ялгаатай чанартай. Тэнгэр улиралтай, газар баялагтай, хүн соёлтой. Тэнгэр, газар байгалийн харилцан үйлчлэлийн үр дүнд юмс үзэгдэл үүссэн ёстой”¹¹ гэж үзсэн. Энэ нь хүн, байгаль, нийгмийн харилцааг шүтэлцүүлэн танин мэдэхийг онцолж үзсэнийг гэрчилнэ.

Ачлалт номд “Ачлалаар эзэндээ үйлчилбэл шударга болно /V бүлэг/” гэдэг нь тахимдуу бол хамгийн түрүүнд шударга ёсыг /ли/ тогтооход тустайг хэлж байна. Мөн ёс зүйн нэр төр гэсэн ойлголтыг авч үзэхдээ: Аливаа хүмүүн эцэг, эхдээ, хаандаа, гэр бүлдээ, ханлиг улсдаа чин сэтгэлээсээ хүндлэлтэй хандваас сайн нэрийг олж алдаршина /XIV бүлэг/. Бусдад хүндлэлтэй байхаас шударга ёсыг тогтоон, өөрийн нэр хүндийг өргөж явах юм. “Ачлалт ном”-д “Гэр дотор эцэг, эх, үх хүүхдээ заан засаж амгалан амьдрах, улсаа засаж олон иргэнийг баярлуулж тахимдуу төр засгийг бий болговоос зовлон самуунгүй дэлхий оршино” /Тажимдуу төрөөр заан засах VIII бүлэг/ гэж нийгмийн нэгж хүрээний ёс суртахууны хүмүүжил, боловсролд анхаарч байхыг сануулжээ. Гэр бүлийн ёс горим алдахгүй дэлхий дахин амар амгалан байхын үндэс болно. Энэ сургаал, ёс орчин үеийн гэр бүлийн ёс суртахууны харилцаанд илэрч байгаа гэр бүл салалт, эхнэр нөхрийн ариун ёс журам алдах, гэр бүлийн үүрэг

хариуцлагаас зайлсхийх, үр хүүхдээ хүмүүжүүлэхэд анхаарахгүй байгаа зэрэг нийтлэг алдаа дутагдлыг уламжлалт арга барилаар засан сайжруулахад тустай юм.

“Сайшаах, жигшихийг үзүүлвэл иргэн цаазыг мэднэ. Таалах, голох хоёрыг зааснаар иргэн засаг хөндөхөө эмээнэ” /VII бүлэг/ гэж тус, гэмийг мэдэх нь төрт ёс, хууль цаазад захирагдах болон тэдгээрийг боловсруулахад тэгшээр оролцогч байх ухамсрыг төлөвшүүлэх ач холбогдолтой болохыг тусгасан. Нөгөө талаар ёс суртахууны хэм хэмжээ, төрийн хууль цаазаас илүү нийгмийг зохицуулах үүрэгтэйг *“Ачлалт ёсыг чухалд үзвэл богд сайд чангагүй ч гэсэн түүний цааз хууль хатуугүй ч гэсэн аяндаа бүтэж төвшин болно”* /IX бүлэг/ хэмээн өгүүлжээ. Бидний үзэхэд Күнзийн ёс зүйн *жэнь, и, ли, синь* хэмээх ойлголтууд “Ачлалт ном”-д бүрэн тусчээ. Нөгөө талаар ачлалын тухай эл сургаал нь Күнзийн дараа үеийн Мэн-зийн “*Өөрийн гэр бүл дэх өвгөдөд зохих ёсоор ханд, өөр бусдын гэр бүлд буй өвгөдөд ч мөн тэгж ханд*”, Ума-3-ын “*Би өөртөө эцэг, эхээсээ илүү хайртай*”, Мо-3-ын “*бүхнийг хамарсан хайрын зарчим*”¹² зэрэг шинэ сургаалууд үүсэх суурь болохын зэрэгцээ, тэднийг бие биенээ шүүмжлэн мэтгэлцэхэд хүргэснээрээ Хятадын ёс зүйн сэтгэлээнд ихээхэн ач холбогдолтой байжээ.

Эл зохиолд эв эе, ачлал, шударга ёс, нэр төр, өршөөл, хүндлэл, хайр зэрэг ёс суртахууны хэм хэмжээг тайлбарлан өгүүлнэ. Хайр, хүндлэл нь ачлалын үндэс бол ачлал нь өршөөл хийгээд соёл сургаалыг бий болгох ажээ. Ийнхүү XIV зуун түүнээс ч өмнө 480 оны орчимд Хятадын их мэргэн Күнзийн сургаал болон сонгодог уран зохиолын дурсгал болох “Шүлэглэлт ном”-оос эшлэн эмхэтгэсэн **ачийг ачаар хариулах ёсны** тухай сургаал монгол хэлнээ орчуулагдаж байв. Уг зохиолын агуулга нь монголчуудын ёс суртахууны үнэлэмж хийгээд сургаалын зохиолуудад тодорхой хэмжээгээр нөлөө тусгалаа үзүүлсэн нь ч эргэлзээгүй.

SUMMARY

In the issue we had tried to analyze Xiaojing “Classic of Filial Piety” of Chinese ethics. The most important source “Benefitable book” is to study history of Mongolian ethics. In the doctrine include fundamental terms of Confucius ethics and meaning Shijing “The book of Songs” of ancient Chinese classic literature.

Ном зүй

1. Ганбаатар.Я, Нангиадын сонгодог утга соёлын товчоон. УБ.,2006
2. Дарьхүү.Р, Г.Эрдэнэбаяр, Философийн түүх. Тэргүүн дэвтэр. УБ.,2004
3. Золзаяа.М, XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог. /Дисс/. УБ.,2007
4. Күнз. Шүүмжлэл өгүүлэл. УБ.,2004 /Орч. Ш.Чимэдцэеэ/
5. Лувсанбалдан.Х, Ачлалт номын тухай. //Studia Mongolica// Tomus III. УБ.,1961
6. Наран.Д, Монголын төр ёсны боловсролын түүх / XIII-XIV зуун /. УБ.,2001

7. Нарантуяа.Ч, Күнз “Ачлалт ном”, “Шударга ном”. УБ.,2004.
8. Орчлонг танихуйн гэгээн шастир. УБ.,2004 /Орч.Д.Наранжаргал/
9. Сүхбаатар.Г, Сүмбэ нар. УБ.,1971
10. Хорин наймтын тайлбар толь. ӨМАХХ.,1994
11. Шагж. Монгол үгийн тайлбар толь. ӨМҮХХ.,1994
12. Фэнь Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003

Зүйлт:

¹ Х.Лувсанбалдан. Ачлалт номын тухай. УБ.,1961. //Studia Mongolica// Tomus III. 36 дахь тал.

² Г.Сүхбаатар. Сүмбэ нар. УБ.,1971

³ Я.Ганбаатар. Нангиадын сонгодог утга соёлын товчоон. УБ.,2006. 423 дахь тал.

⁴ Ч.Нарантуяа.Күнз “Ачлалт ном”, “Шударга ном”. УБ.,2004.

⁵ Д.Наран. Монголын төр ёсны боловсролын түүх / XIII-XIV зуун /. УБ.,2001. 91-98 дахь тал.

⁶ Хорин наймтын тайлбар толь. ӨМАХХ.,1994. 1997 дахь тал.

⁷ Шагж. Монгол үгийн тайлбар толь. ӨМҮХХ.,1994. 584 дэх тал.

⁸ Күнз. Шүүмжлэл өгүүлэл. УБ.,2004. 23 дахь тал.

⁹ М.Золзаяа. XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог. /Дисс/. УБ.,2007. 80 дахь тал.

¹⁰ Орчлонг танихуйн гэгээн шастир. УБ.,2004.

¹¹ Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. Тэргүүн дэвтэр. УБ.,2004. 35 дахь тал.

¹² Фэнь Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003. 71 дэх тал.